

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/134/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/172
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ШИНЭЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022-14/АДБОУС-ЫН
19020533

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,523,065.40</u>	<u>27,747,313.10</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	24,523,065.40	27,747,313.10
351	Түүхий эд материал	842,464.40	2,576,264.40
35110	Тусгай зориулалттай материал	525,264.40	2,576,264.40
35130	Эм боох материал	317,200.00	00.00
354	Хангамжийн материал	22,305,601.00	23,796,048.70
35410	Бичиг хэргийн материал	142,000.00	192,000.00
35420	Аж ахуйн материал	20,208,693.00	21,125,693.00
35460	Хүнсний материал	1,954,908.00	2,478,355.70
35600	Мал амьтад	1,375,000.00	1,375,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>135,528,922.44</u>	<u>147,620,149.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	135,528,922.44	147,620,149.40
392	Биет хөрөнгө	115,734,922.44	127,676,149.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	122,959,200.00	122,959,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,143,176.36	-31,999,004.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,191,103.00	26,205,412.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,623,304.64	-4,599,971.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,985,816.50	28,125,914.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,871,203.06	-15,851,887.75
39217	Ном	2,236,487.00	2,836,487.00
393	Биет бус хөрөнгө	19,794,000.00	19,944,000.00
39301	Программ хангамж	250,000.00	150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,794,000.00	19,794,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>160,051,987.84</u>	<u>175,367,462.50</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>160,051,987.84</u>	<u>175,367,462.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	160,051,987.84	175,367,462.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	135,510,974.00	135,510,974.00
51101	Өмч: - төрийн	135,510,974.00	135,510,974.00
512	Хуримтлагдсан үр дүн	11,871,984.61	27,702,330.11
51210	Өмнөх үеийн үр дүн	11,871,984.61	12,386,855.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,315,474.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,669,029.23	12,154,158.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>160,051,987.84</u>	<u>175,367,462.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	277,514,487.00	258,810,555.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,624,087.00	25,092,455.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,624,087.00	25,092,455.00
120007	Навигацийн орлого	3,499,000.00	22,909,455.00
120008	Монгол банкны ашиг	3,125,087.00	2,183,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,621,100.00	28,122,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	237,269,300.00	205,595,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,117,100.00	7,548,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,117,100.00	7,548,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,504,000.00	20,574,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,504,000.00	20,574,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	285,645,527.26	243,495,080.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,645,527.26	243,495,080.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,450,133.31	220,755,192.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,828,051.95	153,832,852.91
210101	Үндсэн цалин	168,828,051.95	101,771,548.69
210102	Нэмэгдэл	00.00	32,182,147.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,428,615.94
210104	Урамшуулал	00.00	14,450,540.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,790,206.10	19,963,156.26
210201	Тэтгэврийн даатгал	15,221,821.29	14,052,453.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,734,634.15	1,475,402.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,319,227.33	1,204,674.28
210204	Ажилгүйдлийн даатгал	314,658.06	282,004.74
210205	Эрүүл мэндийн даатгал	3,199,865.28	2,948,621.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,871,053.00	18,891,308.00
210301	Гэрэл, цахилгаан	3,235,139.00	1,680,768.00
210302	Түлш, халаалт	11,586,914.00	17,130,040.00
210303	Цэвэр, бохир ус	49,000.00	80,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,459,380.00	1,617,600.00
210401	Бичиг хэрэг	66,800.00	6,000.00
210402	Тээвэр, шатахуун	325,800.00	330,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,000.00	40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,834,700.00	1,240,800.00
210408	Бараа материал акталсны зардал	2,177,080.00	00.00
2105	Нормативт зардал	15,126,116.30	11,708,152.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,590.00	339,200.00
210502	Хоол, хүнс	14,702,326.30	10,502,052.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	357,200.00	866,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	286,000.00	500,000.00

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	286,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	50,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	50,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,039,325.96	14,242,123.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,354,400.00	1,051,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	572,500.00	669,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,112,425.96	12,521,823.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,195,393.95	22,739,887.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,717,100.00	7,548,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,429,300.00	7,548,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,287,800.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,478,293.95	15,191,787.83
213304	Хөрөнгийн	28,478,293.95	15,191,787.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,131,040.26	15,315,474.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	171,172.16	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	171,172.16	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-171,172.16	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,302,212.42	15,315,474.66

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,510,974.00	12,714,252.73	20,128,973.53	168,354,200.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	45,223.50	45,223.50
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,510,974.00	12,714,252.73	20,174,197.03	168,399,423.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,302,212.42	-8,302,212.42
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,510,974.00	12,669,029.23	11,871,984.61	160,051,987.84
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,510,974.00	12,669,029.23	11,871,984.61	160,051,987.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	514,870.84	514,870.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,510,974.00	12,669,029.23	12,386,855.45	160,566,858.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-514,870.84	00.00	-514,870.84
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,315,474.66	15,315,474.66
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,510,974.00	12,154,158.39	27,702,330.11	175,367,462.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	270,890,400.00	233,718,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	270,890,400.00	233,718,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	237,269,300.00	205,595,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,117,100.00	7,548,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,117,100.00	7,548,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,504,000.00	20,574,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,504,000.00	20,574,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	270,890,400.00	233,718,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	270,890,400.00	233,718,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,695,006.05	210,978,212.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,933,051.95	153,832,852.91
210101	Үндсэн цалин	113,370,096.80	101,771,548.69
210102	Нэмэгдэл	33,929,220.32	32,182,147.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	5,428,615.94
210104	Урамшуулал	15,825,734.83	14,450,540.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,790,206.10	19,963,156.26
210201	Тэтгэврийн даатгал	15,945,123.53	14,052,453.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,439,523.90	1,475,402.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,164,359.13	1,204,674.28
210204	Ажилгүйдлийн даатгал	277,599.69	282,004.74
210205	Эрүүл мэндийн даатгал	2,963,599.85	2,948,621.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,962,053.00	18,947,903.00
210301	Гэрэл, цахилгаан	3,235,139.00	1,737,363.00
210302	Түлш, халаалт	11,586,914.00	17,130,040.00
210303	Цэвэр, бохир ус	140,000.00	80,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,849,100.00	3,189,950.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	244,100.00	249,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,450,000.00	2,190,000.00
2105	Нормативт зардал	13,374,795.00	12,547,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,600.00	22,000.00
210502	Хоол, хүнс	12,871,495.00	11,025,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	481,700.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	496,800.00	500,000.00
210604	Урсгал засвар	496,800.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	50,000.00	00.00

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	50,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	256,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,983,000.00	1,996,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,232,600.00	1,255,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,400.00	741,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,195,393.95	22,739,887.83
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	28,478,293.95	15,191,787.83
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	28,478,293.95	15,191,787.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,717,100.00	7,548,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,429,300.00	7,548,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,287,800.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	228,331,800.0	226,170,000.0	2,161,800.0	99.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,331,800.0	226,170,000.0	2,161,800.0	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	228,331,800.0	210,978,212.2	17,353,587.8	92.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,122,400.0	153,832,852.9	3,289,547.1	97.9
210101	Үндсэн цалин	102,560,600.0	101,771,548.7	789,051.3	99.2
210102	Нэмэгдэл	32,492,000.0	32,182,147.5	309,852.5	99.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,720,000.0	5,426,907.7	293,092.4	94.9
210104	Урамшуулал	16,349,800.0	14,452,249.1	1,897,550.9	88.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,211,500.0	19,963,156.3	1,248,343.7	94.1
210201	Тэтгэврийн даатгал	14,926,700.0	14,052,453.3	874,246.8	94.1
210202	Тэтгэмжийн даатгал	1,571,200.0	1,475,402.3	95,797.7	93.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,257,000.0	1,204,674.3	52,325.7	95.8
210204	Ажилгүйдлийн даатгал	314,300.0	282,004.7	32,295.3	89.7
210205	Эрүүл мэндийн даатгал	3,142,300.0	2,948,621.7	193,678.4	93.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,235,900.0	18,947,903.0	3,287,997.0	85.2
210301	Гэрэл, цахилгаан	5,416,900.0	1,737,363.0	3,679,537.0	32.1
210302	Түлш, халаалт	16,619,000.0	17,130,040.0	(511,040.0)	103.1
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	80,500.0	119,500.0	40.3
2104	Хангамж, бараа материалын зардал	3,190,000.0	3,189,950.0	50.0	100.0
210401	Бичиг хэрэг	100,000.0	100,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	250,000.0	249,950.0	50.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.0	200,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	50,000.0	50,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.0	400,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.0	2,190,000.0	-	100.0
2105	Нормативт зардал	21,975,000.0	12,547,500.0	9,427,500.0	57.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.0	22,000.0	23,000.0	48.9
210502	Хоол, хүнс	20,430,000.0	11,025,500.0	9,404,500.0	54.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,500,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.0	500,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	500,000.0	500,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	100,000.0	-	100,000.0	-
210702	Дотоод албан томилолт	100,000.0	-	100,000.0	-

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,997,000.0	1,996,850.0	150.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,256,000.0	1,255,850.0	150.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	741,000.0	741,000.0	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	228,331,800.0	210,978,212.2	17,353,587.8	92.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	205,595,900.0	191,530,309.2	14,065,590.8	93.2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	205,595,900.0	191,530,309.2	14,065,590.8	93.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,735,900.0	19,447,903.0	3,287,997.0	85.5
132001	Орон нутгийн төсвөөс	22,735,900.0	19,447,903.0	3,287,997.0	85.5
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13.0	13.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	6.0	6.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6.0	6.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,117,100.00	7,548,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,117,100.00	7,548,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,717,100.00	7,548,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,717,100.00	7,548,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,429,300.00	7,548,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,287,800.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,117,100.00	7,548,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,117,100.00	7,548,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,117,100.00	7,548,100.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг юм.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын баг нь 2021 онд 26 ажил гүйцэтгэхээр үйл ажиллагааны төлөвлөгөө батлан, дотоод хяналтын ажлаа улирал бүр тайлагнан ажилласан.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба

хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 228,331.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,424.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,568.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 228,331.8 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 226,170.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 7,548.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 233,718.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 18,476.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,386.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 600.0 мянган төгрөгийн ном, 150.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 24,613.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн

хөрөнгөөр худалдан авсан 1,647.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,720.0 мянган төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдлээр 20,246.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Бараа материалын дансанд хандиваар 900.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 18,016.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 16,975.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 27,747.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 147,620.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	24,523.1	27,747.3	3,224.3
Үндсэн хөрөнгө	135,528.9	147,620.2	12,091.2
Нийт хөрөнгө	160,052.0	175,367.5	15,315.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	160,052.0	175,367.5	15,315.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	160,052.0	175,367.5	15,315.5

Бараа материалын дансны үлдэгдэл 27,747.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 3,224.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 147,620.2 мянган төгрөг болж 12,091.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгийн орлого нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 175,367.5 мянган төгрөг болж 15,315.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 297,975.6 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 297,975.6 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 69,643.8 мянган төгрөгөөр буюу 23.4 хувиар бууруулж, 228,331.8 мянган төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 205,595.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 20,574.1 мянган төгрөгийн, нийт 226,170.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 210,978.2 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 15,191.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 210,978.2 мянган төгрөг буюу 92.3 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 7,548.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгалд шилжүүлэгт 7,548.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 18,476.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,386.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 600.0 мянган төгрөгийн ном, 150.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 24,613.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,647.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,720.0 мянган төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдлээр 20,246.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 28,958.6 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, 20,246.1 мянган төгрөгөөр орлогоор бүртгэж тайлагнасан.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 69,643.8 мянган төгрөгөөр буюу 23.4 хувиар бууруулж, 228,331.8 мянган төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан. Төсвийн гүйцэтгэлээр 226,170.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, 210,978.2 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан. Тайлант онд батлагдсан төсвийн нийт 29,1 хувиар хэмнэж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 176 мэдээлэл мэдээлэхээс 174 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1 алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 176 мэдээлэл мэдээлэхээс 174 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянцогт сумын Хүүхдийн цэцэрлэг	1	-	-	-	-	-	-	-	1	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn